

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар -Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/55/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: Я.Марал-эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: maral-erdene@audit.gov.mn Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.5.2.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	13
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗТХ	Авто замын тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ТӨОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.03 № 06/344
танай _____-ны № _____-т

ЗАМ ТЭЭВРИЙН САЛБАРЫН
НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
НЭГЖИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Б.БААТАРЗОРИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газар болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк хооронд 2020 онд байгуулсан зээлийн гэрээний дагуу Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замд нэмэлт 2 эгнээ барих үндсэн 5 багцын 137,000.0 мянган ам.долларын ажлыг 98.1 хувийн гүйцэтгэлтэйгээр ашиглалтад оруулж, 2025 оны 12 дугаар сард хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгэсэн 130.5 км замын хучилтыг 5 см-ээр нэмэгдүүлэх ажлыг Европын сэргээн босголт хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн 20,000.0 мянган ам.долларын нэмэлт санхүүжилтээр гүйцэтгэхээр зарласан тендерт Арж Капитал ХХК, Макс рүүд ХХК-ууд шалгарч 2025 оны 06 дугаар сард гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэл 20.5 хувьтай байна.

Бусад асуудал

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын нэмэлт 5 см хучилтын ажлыг гүйцэтгэгч Макс рүүд ХХК, Арж капитал ХХК-ууд 2025 онд хэрэгжүүлэх "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"-г ирүүлсэн боловч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх заалтын дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тухайн сүм, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлээгүй байх тул төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс албан шаардлага хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	339,655,620,183.44	404,904,983,768.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,442,913.53	192,639,570.67
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,442,913.53	192,639,570.67
31210	Төгрөг	1,442,913.53	39,123,668.49
31211	Төрийн сангийн харилцах	1,442,913.53	39,123,668.49
31220	Гадаад валют	-	153,515,902.18
31221	Төрийн сангийн харилцах	-	153,515,902.18
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	339,654,177,269.91	404,712,344,197.54
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	339,654,177,269.91	404,712,344,197.54
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,430,323.78	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,430,323.78	-
39200	Биет хөрөнгө	5,782,579.54	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	19,939,000.00	19,939,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,156,420.46)	(19,939,000.00)
39300	Биет бус хөрөнгө	1,647,744.24	-
39301	Програм хангамж	3,300,000.00	3,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,652,255.76)	(3,300,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	339,663,050,507.22	404,904,983,768.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,900,099.09	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,900,099.09	-
41300	Өглөг	22,900,099.09	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	22,900,099.09	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	339,640,150,408.13	404,904,983,768.21
51	Засгийн газрын хувь оролцоо	339,640,150,408.13	404,904,983,768.21
51200	Хуримтлагдсан үр дүн	339,640,150,408.13	404,904,983,768.21
51210	Өмнөх үеийн үр дүн	229,282,893,417.35	339,640,150,408.13
51220	Тайлант үеийн үр дүн	110,357,256,990.78	65,264,833,360.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	339,663,050,507.22	404,904,983,768.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	109,501,733,027.33	51,765,466,103.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109,501,733,027.33	51,765,466,103.96
120	Нийтлэг татварын бус орлого	109,501,733,027.33	51,765,466,103.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	109,501,733,027.33	51,765,466,103.96
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	109,501,733,027.33	51,765,466,103.96
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	463,203,289.21	422,313,069.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,203,289.21	422,313,069.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,203,289.21	422,313,069.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,468,409.09	302,222,796.48
210101	Үндсэн цалин	308,468,409.09	302,222,796.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,558,551.14	37,777,849.55
210201	Тэтгэврийн даатгалын зардал	26,219,814.77	25,688,937.69
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,084,684.09	3,022,227.97
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,542,342.05	1,511,113.98
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,542,342.05	1,511,113.98
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	6,169,368.18	6,044,455.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,656,000.00	27,778,516.13
210304	Байрны түрээс	46,656,000.00	27,778,516.13
2104	Хангамж, бараа материалын зардал	11,931,757.78	9,298,385.79
210401	Бичиг хэрэг	9,420,273.00	7,494,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,511,484.78	1,803,585.79
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,305,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,305,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	40,634,675.00	21,995,750.00
210702	Дотоод албан томилолт	40,634,675.00	21,995,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,013,000.00	15,809,448.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,809,448.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	12,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,013,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,635,396.20	7,430,323.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,635,396.20	7,430,323.78
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	109,038,529,738.12	51,343,153,034.23
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,318,727,252.66	13,921,846,212.38
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,318,727,252.66	13,921,846,212.38
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	165,886.53
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	165,886.53
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	1,318,727,252.66	13,921,680,325.85
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	110,357,256,990.78	65,264,833,360.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428,667,793.92	437,782,845.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,667,793.92	437,782,845.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	428,667,793.92	437,782,845.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,568,310.00	325,122,895.57
210101	Үндсэн цалин	285,568,310.00	325,122,895.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,558,551.14	37,777,849.55
210201	Тэтгэврийн даатгалын зардал	26,219,814.77	25,688,937.69
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,084,684.09	3,022,227.97
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,542,342.05	1,511,113.98
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,542,342.05	1,511,113.98
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	6,169,368.18	6,044,455.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,656,000.00	27,778,516.13
210304	Байрны түрээс	46,656,000.00	27,778,516.13
2104	Хангамж, бараа материалын зардал	11,931,757.78	9,298,385.79
210401	Бичиг хэрэг	9,420,273.00	7,494,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,511,484.78	1,803,585.79
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,305,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,305,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	40,634,675.00	21,995,750.00
210702	Дотоод албан томилолт	40,634,675.00	21,995,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,013,000.00	14,159,448.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	10,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,013,000.00	2,159,448.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,650,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,650,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(428,667,793.92)	(437,782,845.04)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-
14	Бусад эх үүсвэр	-	629,145,388.71
1451	Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	629,145,388.71
145102	Бусад засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	629,145,388.71
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	48,785.06	165,886.53
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	48,785.06	165,886.53
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(48,785.06)	628,979,502.18
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(428,716,578.98)	191,196,657.14
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	430,159,492.51	1,442,913.53
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,442,913.53	192,639,570.67

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,282,893,417.35	229,282,893,417.35
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	229,282,893,417.35	229,282,893,417.35
9	Тайлант үеийн үр дүн	110,357,256,990.78	110,357,256,990.78
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,640,150,408.13	339,640,150,408.13
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,640,150,408.13	339,640,150,408.13
19	Тайлант үеийн үр дүн	65,264,833,360.08	65,264,833,360.08
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	404,904,983,768.21	404,904,983,768.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,294,370,000.00	51,574,103,560.29	720,266,439.71	98.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	494,370,000.00	437,782,845.04	56,587,154.96	88.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	494,370,000.00	437,782,845.04	56,587,154.96	88.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,000,000.00	325,122,895.57	14,877,104.43	95.6
210101	Үндсэн цалин	340,000,000.00	325,122,895.57	14,877,104.43	95.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,500,000.00	37,777,849.55	4,722,150.45	88.9
210201	Тэтгэврийн даатгал	28,900,000.00	25,688,937.69	3,211,062.31	88.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,400,000.00	3,022,227.97	377,772.03	88.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,700,000.00	1,511,113.98	188,886.02	88.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,700,000.00	1,511,113.98	188,886.02	88.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6,800,000.00	6,044,455.93	755,544.07	88.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,000,000.00	27,778,516.13	17,221,483.87	61.7
210304	Байрны түрээс	45,000,000.00	27,778,516.13	17,221,483.87	61.7
2104	Хангамж, бараа материалын зардал	12,020,000.00	9,298,385.79	2,721,614.21	77.4
210401	Бичиг хэрэг	8,400,000.00	7,494,800.00	905,200.00	89.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,620,000.00	1,803,585.79	1,816,414.21	49.8
2107	Томилолт, зочны зардал	35,250,000.00	21,995,750.00	13,254,250.00	62.4
210702	Дотоод албан томилолт	35,250,000.00	21,995,750.00	13,254,250.00	62.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,600,000.00	14,159,448.00	440,552.00	97.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,100,000.00	2,000,000.00	100,000.00	95.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,500,000.00	2,159,448.00	340,552.00	86.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	1,650,000.00	3,350,000.00	33.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	1,650,000.00	3,350,000.00	33.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,800,000,000.00	51,136,320,715.25	663,679,284.75	98.7
220001	Барилга байгууламж	51,800,000,000.00	51,136,320,715.25	663,679,284.75	98.7
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(52,294,370,000.00)	(51,574,103,560.29)	(720,266,439.71)	98.6
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,294,370,000.00	51,574,103,560.29	720,266,439.71	98.6

**Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(191,362,543.67)	191,362,543.67	-
72	ЗГ-ын зээл	52,294,370,000.00	51,765,466,103.96	528,903,896.04	99.0
722	Гадаад	52,294,370,000.00	51,765,466,103.96	528,903,896.04	99.0
7221	Төслийн зээл	52,294,370,000.00	51,765,466,103.96	528,903,896.04	99.0
322101	Шинээр авах	52,294,370,000.00	51,765,466,103.96	528,903,896.04	99.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,277,027.00	(1,277,027.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	192,639,570.67	(192,639,570.67)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	6	4	60.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	5	4	55.6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10	6	4	60.0
650013	Шатлалгүй цалин	10	6	4	60.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ барих төсөл нь Монгол Улсын Засгийн газар болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хооронд байгуулсан 2020 оны MN50766 дугаартай гэрээний дагуу 137,000.0 мянган ам.долларын зээлийг олгосон. Тус зээлийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн оруулан зээлийн хэмжээг 20,000.0 мянган ам,доллараар нэмэгдүүлж, нийт төслийн дүн 157,000.0 мянган ам.доллар болсон байна.

Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ барих төслийн нэгж нь зорилгоо “Төслийн хүрээнд дотоод болон олон улсын зорчих хөдөлгөөний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахуйц авто замын багтаамжийг нэмэгдүүлж, аюулгүй байдал ба уур амьсгалын нөлөөлөлд тэсвэртэй байдлыг мэдэгдэхүйц сайжруулна. Үүний үр дүнд бүс нутгийн хотууд ба хоёрдогч төвүүдийн уялдаа холбоо сайжирч, замын нөхцөл, гүүр, ус зайлуулах байгууламж, гэрэлтүүлэг, тэмдэг тэмдэглэгээ сайжирснаар эдийн засаг, ажлын байр, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах” гэж тодорхойлсон байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Төслийн техник, эдийн засгийн үнэлгээ, зурган төсөл боловсруулах, батлуулах;
- Азийн хөгжлийн банкны 130.5 км замыг нэмэлт 5 см-ээр нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөө батлах;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах;
- Нэмэлтээр хийж гүйцэтгэх ус зайлуулах байгууламж болон орц гарцын асуудлыг шийдвэрлэх;
- Хурд сааруулагчийг шинэчлэгдсэн стандартын дагуу хийх;
- Дуу чимээ тусгаарлах хашилт суурилуулах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улаанбаатар-Дархан чиглэлийн зам нь Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр, бүс ба зам санаачилга болон БНХАУ-Монгол Улс-ОХУ эдийн засгийн коридор санаачилгын хүрээнд хамрагдах эдийн засаг, худалдааны чухал ач холбогдол бүхий коридор бөгөөд Монгол Улсын Засгийн газрын зүгээс энэхүү коридорыг 4 урсгалтай буюу Asia Highway 3 стандартын 1 дүгээр зэрэглэл (Class 1, Asia Highway 3 standard)-ийн зам болгохоор ажиллаж Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөл хариуцсан нэгж юм.

Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төсөл нь Хувь хүний нууцын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Татварын багц хуулиуд, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралт Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам, болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 5 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;

- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 112 дугаар тушаал
- Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон ,бүтэц, орон тоог батлах тухай Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 174 тоот тушаал.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналт

Сангийн яамны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, үнэлгээний газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Улаанбаатар Дарханы замд 2 эгнээ зам барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд чиглэнэ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,241,933.2 мянган төгрөгөөр буюу 19.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	1,442.9	192,639.6	191,196.6
Бараа материал	339,654,177.2	404,712,344.2	65,058,166.9
Үндсэн хөрөнгө	7,430.3	-	7,430.3
Нийт хөрөнгө	339,663,050.5	404,904,983.7	65,241,933.2
Богино хугацаат өр төлбөр	22,900.1	-	22,900.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	339,640,150.4	404,904,983.7	65,264,833.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	339,663,050.5	404,904,983.7	65,241,933.2

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 191,196.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны зардлыг дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.
- Бараа материал дансны үлдэгдэл оны эхнээс 65,058,166.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлан онд гадаад зээл тусламжаар хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэл бараа материал нэмэгдсэнээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,430.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны 7,430.3 төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 616,362.1 мянган төгрөг, нийт зарлагыг 616,362.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 68,330.0 мянган төгрөг, НДШ-ийн зардлыг 8,541.3 мянган төгрөг, байрны түрээсийн зардлыг 13,600.0 мянган төгрөг, хангамжийн зардлыг 3,330.8 мянган төгрөг, албан томилолтын зардлыг 25,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээний төлбөр хураамжийг 1,800.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,500.0 мянган төгрөг, нийт 122,102.1 мянган төгрөгөөр бууруулж, 494,370.0 мянган төгрөг, төслийн зээлээр 52,294,370.0 мянган төгрөгийг хянан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 437,782.8 мянган төгрөгөөр санхүүжиж, 437,782.8 мянган төгрөгийг зарцуулсан. Гадаадын эх үүсвэрээс 51,765,466.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 51,574,103.6 мянган төгрөгийг зарцуулж долларын дансанд 191,362.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 51,574,103.6 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 14,877.1 мянган төгрөг, НДШ-ийн зардал 4,722.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 2,721.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 440.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3,350.0 мянган төгрөг, төслийн зээлийн зардал 663,679.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70207-83112 гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	494,370.0	437,782.8	56,587.2	88.5
2	70207-80104 гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил	51,800,000.0	51,136,320.7	663,679.3	98.7
Нийт		52,294,370.0	51,574,103.6	720,266.5	

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Улаанбаатар Дарханы нэмэлт 2 эгнээ зам барих төслийн нэгжийг Сангийн сайдын 2023 оны 113 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог удирдах -1, гүйцэтгэх-9 байхаар тогтоосон ба гүйцэтгэлээр удирдах -1, гүйцэтгэх-5 нийт 6 орон тоогоор ажилласан байна.
- Санхүүгийн программ Асoulos программыг 2024 оноос эхлэн ашиглаж байна.
- Тайланд онд гадаад томилолт, сургалт арга хэмжээ, хэвлэл мэдээллийн байгууллагатай хийсэн гэрээний зардлыг төлөвлөөгүй, тайлант онд санхүүжүүлээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төслийн хүрээнд нийт 137,000.0 мянган ам.долларын 5 багц ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсвийн хэрэгжилтийн түвшин 98.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Багц-1: Баруун аймаг салах тойрог уулзвараас хар модот давааны ар хүртэлх 37.282 км авто замын гүйцэтгэгчээр “Арж капитал” ХХК болон “М-ойл групп” ХХК-ийн түншлэл шалгарч 100 хувийн гүйцэтгэлээр улсын комисс хүлээн авсан.
- Багц-2 Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто замын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Жунмэй Инженеринг групп ХХК шалгарч үндсэн барилгын ажил дуусаж, карьерын нөхөн сэргээлтийн болон нэмэлт ажил дутуу гүйцэтгэл 97.6 хувьтай байна.
- Багц-3: Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэл 45.753 км авто замын гүйцэтгэгчээр БНХАУ-ын Жунмэй групп инженеринг групп ХХК шалгарч барилгын үндсэн ажил дуусаж, карьерын нөхөн сэргээлт болон нэмэлт ажил үлдээд байгаа ба гүйцэтгэл 99.0 хувьтай.
- Багц-4: Сүмбэрийн уулзвараас цайдмын хөндий хүртэлх 45.05 км авто замын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шанхай Констракшн групп” ХХК шалгарч барилгын үндсэн ажил дуусаж, карьерийн нөхөн сэргээлт болон нэмэлт ажил дутуу, гүйцэтгэл 99.0 хувьтай;
- Багц-5 Цайдмын хөндийгөөс Дарханы тойрог уулзвар хүртэлх 28.84 км авто замын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Чайна Гэжүбэ групп “ХХК авто замын гүйцэтгэгчээр шалгарч, барилгын үндсэн ажил дуусаж, карьерын нөхөн сэргээлт, төлбөр авах цэгийн барилгын ажил болон нэмэлт ажил дутуу, гүйцэтгэл 95.0 хувьтай, нийт 5 багцын ажлыг 98.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.
- Зам барилгын ажлын техник , технологийн хяналтын зөвлөх үйлчилгээгээр “Ай Ар Ди Инженернг Интерконтинентал Консалтантс, Технократс” ХХК-ийн түншлэл болон хамтран оролцогч Монгол улсын” Ай Си Ти Сайн консалтинг ХХК” тус тус шалгарч гүйцэтгэсэн байна.

Азийн хөгжлийн банкны 130.5 км авто замыг нэмэлт 5 см асфальт бетон хучилтаар нэмэгдүүлэх ажил нийт 2 багц ажлын гүйцэтгэл:

- Багц-1: Баруун аймаг салах тойрог уулзвараас урьхан хүртэл 65 км авто замын гүйцэтгэгчээр “Макс Реүд” ХХК шалгарч 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэл 20.5 хувь;

- Багц-2: Урьханаас Дархан-Эрдэнэтийн уулзвар хүртэлх 65 км авто замын гүйцэтгэгчээр “Арж капитал” ХХК тус тус шалгарч 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэл 20.5 хувьтай байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд өсөл хэрэгжүүлэгч нэгж дээр худалдан авах ажиллагааны тендер зарлагдаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, шилэн данс, үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Сожидмаа Компанийн захирал С.Тунгалаг, анхан шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Я.Марал-эрдэнэ аудитын менежер Д.Энхдалай, Газрын захирал тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 03/430 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг 2025 оны үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 322,234.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,234.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт 163 мэдээлэл байршуулахаас 153 мэдээллийг хугацаанд байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж үзсэн.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Азийн хөгжлийн банкны 130.5 км замын нэмэлт 5 см асфалтът бетон хучилтаар нэмэгдүүлэх, Европын сэргээн босголт хөгжлийн банкны 20,000.0 мянган ам.долларын буцалтгүй тусламжаар хийгдэх ажлын гүйцэтгэлийг дараагийн аудитаар хянан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 51,833,955.5 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 51,833,955.5 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

- Мөнгөн гүйлгээний тайланд ҮОМШӨ-ний даатгалын зардлыг 156.8 мянган төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,576.7 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,815.0 мянган төгрөгөөр нийт 3,548.5 мянган төгрөгөөр илүү, тэтгэмжийн зардлыг 682.4 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын зардлыг 1,051.1 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 165.0 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 8,095.7 мянган төгрөгөөр, нийт 9,994.2 мянган төгрөгөөр дутуу, нийт 13,542.7 мянган төгрөгөөр мөнгөн хөрөнгийн журналаас зөрүүтэй тайлагнасан;
- Тайлант оны мөнгөн гүйлгээний тайлангийн үлдэгдэл нь санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлээс 51,820,412.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Эдгээр нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Аудитаар нийт 19,939.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс буюу 32,234.1 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажилтнуудаас хөрөнгийг хүлээн авсан жагсаалт, актгүй нийт 19,939.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-д “Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед; эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед тогтмол тооллого хийж, хөрөнгийг актаар хүлээлцэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Улаанбаатар -Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн гүйлгээний тайланд ҮОМШӨ-ний даатгалын зардлыг 156.8 мянган төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,576.7 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,815.0 мянган төгрөгөөр нийт 3,548.5 мянган төгрөгөөр илүү, тэтгэмжийн зардлыг 682.4 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даагалын зардлыг 1,051.1 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 165.0 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 8095.7 мянган төгрөгөөр нийт 9,994. 2 мянган төгрөгөөр дутуу, нийт 13,542.7 мянган төгрөгөөр мөнгөн хөрөнгийн журналаас зөрүүтэй тайлагнасан байна.	1	13,542.8			1	13,542.8	1	13,542.8	-	-	-	-
2	Тайлант оны мөнгөн гүйлгээний тайлангийн үлдэгдэл нь санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлээс 51,820,412.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна	1	51,820,412.7			1	51,820,412.7	1	51,820,412.7				
	Дүн	2	51,833,955.5			2	51,833,955.5	2	51,833,955.5	-	-	-	-

Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Өмнөх төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажилтнуудаас хөрөнгийг хүлээн авсан жагсаалт, актгүй нийт 19,939.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	19,939.0	-	-	-	-	1	19,939.0	-	-	-	-
	Дүн	2	19,939.0					2	19,939.0	-	-	-	-

Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны нэгдсэн системд нийт 163 мэдээлэл байршуулахаас 153 мэдээллийг хугацаанд байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-